



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2, 63.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэг, хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

2. Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтыг тогтоол батлагдсан өдрөөс, хоёрдугаар хавсралтыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтыг дагаж мөрдсөн өдрөөс мөн тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны
3 дугаар сарын 23-ны өдрийн 94 дугаар
тогтоолын 01 дүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЗАРИМ ЭТГЭЭДИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ А0410 5043239

№	Эрхлэх үйл ажиллагаа	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ (Сая.төгрөг)
1.	Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	10.0
2.	Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа	50.0
3.	Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа	50.0
4.	Андеррайтерийн үйл ажиллагаа	200.0
5.	Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа	1,000.0
6.	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа	100.0
7.	Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа	100.0
8.	Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа	100.0
9.	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа /кастодиан/	1,000.0

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны
3 дугаар сарын 23-ны өдрийн 4 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЗАРИМ ЭТГЭЭДИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

№	Эрхлэх үйл ажиллагаа	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ (Сая.төгрөг)
1.	Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	30.0
2.	Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа	100.0
3.	Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа	200.0
4.	Андеррайтерийн үйл ажиллагаа	1,000.0
5.	Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа	2,000.0
6.	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа	2,000.0
7.	Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа	2,000.0
8.	Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа	2,000.0
9.	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа /кастодиан/	1,000.0